



МОНГОЛ УЛСЫН  
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2021 оны 3 сарын 11 өдөр

Дугаар 029

Улаанбаатар хот

Сонгууль ажиглах журам шинэчлэн  
батлах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.6 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.6 дахь хэсэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.6 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:


1.“Сонгууль ажиглах нийтлэг журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Сонгууль ажиглагчийн ёс зүйн дүрэм”-ийг 2 дугаар хавсралтаар, “Ажиглагчийн бүртгэл”-ийн маягтыг 3 дугаар хавсралтаар, “Гадаадын ажиглагч /орчуулагч/-ийн өргөдөл”-ийн маягтыг 4 дүгээр хавсралтаар, “Ажиглагчийн үнэмлэх”-ийн загварыг 5 дугаар хавсралтаар, “Гадаадын ажиглагчийн үнэмлэх”-ийн загварыг 6 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг бүх шатны сонгуулийн хороодод, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хорооны нарийн бичгийн дарга /Д.Даваа-Очир/-даа алгасугай.

3.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн “Сонгууль ажиглах журам батлах тухай” 14 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



П.ДЭЛГЭРНАРАН

Д.ДАВАА-ОЧИР

0000057

Сонгуулийн ерөнхий хорооны  
2021 оны 3. дугаар сарын 1.-ны өдрийн  
29.. дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

## СОНГУУЛЬ АЖИГЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Сонгуулийн үйл ажиллагаа хууль тогтоомжийн хүрээнд явагдаж байгаа эсэхэд хөндлөнгийн ажиглалт хийхтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Сонгууль ажиглахтай холбогдсон үйл ажиллагаанд энэ журам болон сонгуулийн тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

1.3. Ажиглагч гэж холбогдох шатны сонгуулийн байгууллагад бүртгүүлэн үнэмлэх авсан, 18 нас хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай Монгол Улсын болон гадаад улсын иргэдийг ойлгоно.

1.4. Ажиглагчдыг дараах этгээд томилон ажиллуулж болно:

1.4.1. сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, эсхүл нэр дэвшигч;

1.4.2. Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн төрийн бус байгууллага;

1.4.3. гадаадын болон олон улсын байгууллага, гадаад улсаас Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газар.

1.5. УИХ-ын сонгуулийн тухайд нам, эвсэл, эсхүл нэр дэвшигч нэг санал авах байранд 4 хүртэл, орон нутгийн сонгуулийн тухайд нам, эвсэл, эсхүл нэр дэвшигч нэг санал авах байранд 3 хүртэл, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухайд нэр дэвшигч нэг санал авах байранд 3 хүртэл ажиглагч томилон ажиллуулах эрхтэй.

1.6. Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн төрийн бус байгууллага нэг санал авах байранд 2 хүртэл ажиглагчийг томилон ажиллуулах эрхтэй.

1.7. Ажиглагч нь сонгууль ажиглахдаа Монгол Улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөх ба энэ журмын хавсралтаар баталсан ажиглагчийн ёс зүйн дүрэмтэй танилцаж, гарын үсэг зурсан байна.

1.8. Ажиглагч бүртгүүлэх хүсэлт гаргасан бүх байгууллага ажиглагчийн ёс зүйн дүрэм болон сонгуулийн тухай хууль тогтоомжийг өөрийн илгээж буй ажиглагчдад танилцуулах үүргийг хүлээнэ.

1.9. Сонгууль ажигласан этгээд ажиглалтын тайлангаа зөвлөмжийн хамт Сонгуулийн ерөнхий хорооны [desc@gec.gov.mn](mailto:desc@gec.gov.mn) цахим хаягаар хүргүүлнэ.

## **Хоёр. Ажиглагч бүртгүүлэх хүсэлт гаргах**

2.1. Энэ журмын 1.4.1, 1.4.2-т заасан этгээд ажиглагч ажиллуулах, бүртгүүлэх хүсэлтийг бүртгэлийн маягтын дагуу гаргаж, санал авах өдрөөс 5-аас доошгүй хоногийн өмнө дараах баримт бичгийн хамт цаасан, эсхүл цахим хэлбэрээр хэсгийн хороонд хүргүүлнэ:

- 2.1.1. ажиглагчаар томилсон шийдвэрийн хуулбар;
- 2.1.2. маягтын дагуу гаргасан ажиглагчийн өргөдөл;
- 2.1.3. нэг хувь 3x4 хэмжээтэй цээж зураг;
- 2.1.4. иргэний үнэмлэхийн хуулбар;
- 2.1.5. ёс зүйн дүрмийг дагаж мөрдөхөө илэрхийлэн гарын үсэг зурсан уг дүрмийн хуулбар.

2.2. Гадаадын болон олон улсын байгууллага, гадаад улсаас Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газар, гадаад улсын иргэн /цаашид “гадаадын ажиглагч” гэх/ сонгууль ажиглах, ажиглагчаар бүртгүүлэх хүсэлтээ дараах баримт бичгийн хамт цаасан, эсхүл цахим хэлбэрээр Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлнэ:

- 2.2.1. ажиглагчаар томилсон тухай холбогдох байгууллагын албан хүсэлт;
- 2.2.2. маягтын дагуу гаргасан ажиглагчийн өргөдөл;
- 2.2.3. нэг хувь 3x4 хэмжээтэй цээж зураг;
- 2.2.4. гадаад паспортын хуулбар.
- 2.2.5. ёс зүйн дүрмийг дагаж мөрдөхөө илэрхийлэн гарын үсэг зурсан уг дүрмийн хуулбар.

2.3. Ажиглагчийн бүртгэлийг цахимаар хийхдээ Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудсаар дамжуулан гүйцэтгэнэ.

## **Гурав. Ажиглагч бүртгэх, үнэмлэх олгох**

3.1. Сонгуулийн ерөнхий хороо энэ журмын 2.2-т заасны дагуу ирүүлсэн хүсэлт, холбогдох баримт бичгийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор нягтлан шалгаж, хуульд заасан шаардлага хангасан этгээдийг гадаадын ажиглагчаар бүртгэж, үнэмлэх олгоно.

3.2. Хэсгийн хороо энэ журмын 2.1-д заасны дагуу ирүүлсэн хүсэлт, холбогдох баримт бичгийг хүлээн авч, санал авах өдрөөс 2-оос доошгүй хоногийн өмнө хуульд заасан шаардлага хангасан этгээдийг ажиглагчаар бүртгэж, үнэмлэх олгоно.

3.3. Хэсгийн хороо энэ журмын 2.1-д заасан баримт бичиг дутуу, шаардлага хангахгүй тохиолдолд хуульд заасан хугацаанд багтаан баримт бичгийн зөрчлийг арилгуулах, дахин бүрдүүлж ирүүлэхийг шаардах эрхтэй.

3.4. Гадаадын ажиглагчийн орчуулагч нь гадаадын ажиглагчийн нэгэн адил бүртгүүлж, үнэмлэх авсан байна.

3.5.Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо өөрийн харьялах сум, дүүргийн сонгуулийн хороодоос сонгуулийн хэсэг тус бүрээр гаргасан ажиглагчдын талаарх мэдээллийг нэгтгэн, санал авах өдрөөс өмнө Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлнэ.

### **Дөрөв. Сонгууль ажиглах**

4.1.Ажиглагч нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1-д заасны дагуу санал авах, тоолох, дүн гаргах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу явагдаж байгаа эсэхийг зөвхөн хөндлөнгөөс ажиглах бөгөөд сонгуулийн тухай хууль тогтоомжид заасан эрх эдэлнэ.

4.2.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.12, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.12, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.12-т заасны дагуу санал авах байрын багтаамжаас хамаарч бүх ажиглагч санал авах байранд нэгэн зэрэг ажиглалт хийх боломжгүй бол хэсгийн хороо ажиглагч томилох эрх бүхий этгээдийн тус бүр нэг ажиглагчийг ээлжээр ажиглалт хийх боломжоор хангана.

4.3.Ажиглагч нь хэсгийн хорооны ажилд хөндлөнгөөс оролцох, сонгогчийн сонгох эрхэд саад учруулах, хуульд заагаагүй эрх эдлэхийг шаардах эрхгүй.

4.4.Санал авах байранд санал авах ажиллагааг Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.11-д заасан хяналтын камер болон цахимаар ажиглах боломжоор хангана.

### **Тав. Сонгуулийн автоматжуулсан системийн ажиллагааг ажиглах**

5.1.Сонгуульд оролцож буй нам, эвслийн болон сонгуулийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хийх эрх бүхий төрийн бус байгууллагуудын төлөөлөл сонгуулийн автоматжуулсан системийн иж бүрдэл, програм хангамжийг шалган турших, баталгаажуулах ажлыг ажиглах эрхтэй.

5.2.Сонгуулийн автоматжуулсан системтэй холбоотой ажиглалт хийх хүсэлтийг Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвд дараах баримт бичгийн хамт энэ журмын 5.1-д заасан ажиллагаа эхлэхээс өмнө хүргүүлэн бүртгүүлнэ:

5.2.1.ажиглагчаар томилсон шийдвэрийн хуулбар;

5.2.2.маягтын дагуу гаргасан ажиглагчийн өргөдөл;

5.2.3.нэг хувь 3x4 хэмжээтэй цээж зураг;

5.2.4.иргэний үнэмлэхийн хуулбар;

5.2.5.ёс зүйн дүрмийг дагаж мөрдөхөө илэрхийлэн гарын үсэг зурсан уг дүрмийн хуулбар.

### **Зургаа. Бусад**

6.1. Сонгуулийн үйл ажиллагааг ажиглахаар хүсэлт гаргасан этгээд нь сонгууль ажиглахтай холбогдон гарах зардлаа бүрэн хариуцна. Гадаадын ажиглагчийн Монгол Улсад зорчих эрх, Монгол Улсад байх зөвшөөрөл болон сонгууль ажиглахтай холбогдон гарах бусад зардлыг түүнийг урьсан болон илгээсэн тал, эсхүл ажиглагч өөрөө хариуцна.

6.2. Ажиглагч сонгуулийн хууль тогтоомж илтэд зөрчсөн шинжтэй үйлдэл гаргасан тохиолдолд хэсгийн хорооны дарга цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ.

6.3. Ажиглагч энэ журам болон сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд хэсгийн хорооны дарга ажиглагчийн бүртгэлийг хүчингүй болгож, санал авах байраас гаргана.

6.4. Гадаадын ажиглагч сонгуулийн тухай хууль тогтоомж, ажиглагчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн тохиолдолд хэсгийн хорооны дарга тухайн ажиглагчид сануулга өгч, ажиглагчийг анх бүртгэсэн байгууллага (сонгуулийн төв байгууллага)-д нэн даруй мэдэгдэнэ. Ажиглагч сануулгыг үл хэрэгссэн бол энэ тухай ажиглагчийг анх бүртгэсэн байгууллагад мэдэгдэн санал авах байрнаас гаргах хүртэл арга хэмжээ авч болно.

6.5. Ажиглагч сонгуулийн тухай хууль болон энэ журамд заасныг зөрчвөл холбогдох хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---оОо---

Сонгуулийн өрөнхий хорооны  
2021 оны 3 дугаар сарын // .ны өдрийн  
29 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

## СОНГУУЛЬ АЖИГЛАГЧИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Сонгууль ажиглагч миний бие Монгол Улсын тусгаар тогтнол, ард түмний зан заншил, өв соёл, үндсэн эрх, эрх чөлөөг хүндэтгэн сонгуулийг эрх тэгш, шударга зарчмаар, хууль тогтоомжийн дагуу явагдаж байгаа эсэхийг зөвхөн хөндлөнгөөс ажиглахдаа энэхүү ёс зүйн дүрмийг чанд мөрднө.

1. Монгол Улсын сонгуулийг ажиглахдаа хууль тогтоомжийг дагаж мөрдөх ба сонгуулийн байгууллага, ажилтнууд, сонгуулийн үйл ажиллагааны бусад оролцогчдод хүндэтгэлтэй хандана.
2. Монгол Улсын иргэдийн сонгох, сонгогдох эрхийг дээдлэн алагчлалгүй хандана.
3. Монгол Улсын төрийн эрх бүхий байгууллага, улс төрийн нам, нэр дэвшигчид, түүнчлэн сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой асуудалд тэгш хандана.
4. Ажиглагч нь сонгуулийн бүхий л үе шатанд шударга байдлыг эрхэмлэх ба санал авах ажиллагааг ажиглах үедээ улс төрийн нам, нэр дэвшигчийг дэмжсэн, эсвэл эсэргүүцсэн хандлага бүхий аливаа үйлдэл, үйл ажиллагаа зохион байгуулахгүй, оролцохгүй байх, сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн уриа, нэр, туг далбаа, бэлгэ тэмдэг, тэдгээрийн өнгө бүхий хувцас хэрэглэл хэрэглэхгүй.
5. Ажиглагч нь сонгуулийн байгууллагын ажилтнаас аливаа асуудлаар асуулт асуух, тодруулга хийх, хүсэлт гаргах эрхтэй боловч сонгуулийн үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар саад учруулах, хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.
6. Ажиглагч сонгууль ажиглах явцдаа ажиглагчийн үнэмлэхээ ил харагдахуйц байдлаар зүүсэн байх ба сонгуулийн байгууллагын ажилтан, бусад эрх бүхий байгууллагын хүсэлтээр биеийн байцаалтаа тухай бүр үзүүлнэ.
7. Сонгууль ажиглагчийг илгээсэн байгууллага, сонгууль ажиглах багийн эрх бүхий этгээд сонгуулийн үйл явцын талаар ярилцлага, мэдээлэл өгч болно. Сонгууль ажиглалтын албан ёсны тайлан гараагүй байхад сонгуулийн үйл ажиллагааг дүгнэж хувийн үзэл бодлоо илэрхийлсэн утга агуулга бүхий мэдэгдэл, тайлбарыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр нийтлэхээс зайлсхийнэ.
8. Энэхүү дүрмийг зөрчсөн тохиолдолд ажиглагчийн эрх олгосон сонгуулийн байгууллага нь тухайн ажиглагчийн сонгууль ажиглах эрхийг цуцлах хүртэл арга хэмжээ авах эрхтэй.
9. Ажиглагч Монгол Улсын Засгийн газар, эрх бүхий байгууллагаас гаргасан аюулгүй байдлыг сахин хамгаалах заавар, зөвлөмжийг даган мөрднө.

Ёс зүйн дүрэмтэй танилцаж хүлээн зөвшөөрсөн:

-ын ажиглагч

/төлөөлж буй этгээдийн нэр/

/Ажиглагчийн нэр/

/Ажиглагчийн гарын үсэг/

\_\_\_\_\_ он \_\_\_\_\_ сар \_\_\_\_\_ өдөр

Сонгуулийн өрөнхий хорооны  
2021 оны 3.. дугаар сарын ...-ны өдрийн  
29.. дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

АЖИГЛАГЧИЙН БҮРТГЭЛ

Д/д	Овог, нэр	Регистрийн дугаар	Нас	Хүйс	Төлөөлж буй нам, эвсэл, төрийн бус байгууллага, эсхүл нэр дэвшигчийн нэр	Утасны дугаар
1						
2						
3						
4						

Сонгуулийн ерөнхий хорооны  
2021 оны 2... дугаар сарын ...-ны өдрийн  
29 дугаарт тогтоодын 4 дүгээр хавсралт

**ГАДААДЫН АЖИГЛАГЧ /ОРЧУУЛАГЧ/-ИЙН**

/аль нь болохын доогур зурж тэмдэглэнэ/

**ӨРГӨДӨЛ**

3 x 4  
зураг

Огноо: 20...оны....дугаар сарын.....-ныөдөр

1	Овог, эцэг /эх/-ийн нэр	
2	Өөрийн нэр	
3	Төрсөн он, сар	
4	Хүйс	
5	Иргэншил	
6	Паспортын төрөл, дугаар, хүчинтэй хугацаа	
7	Төлөөлж буй улс, байгууллагын нэр	
8	Эрхэлж буй ажил, албантушаал	
9	Мэргэжил	
10	Урьсан байгууллагын нэр	
11	Ажиглагчийн орчуулагч /туслах хүний нэр, цахим шуудангийн хаяг, утасны дугаар	
12	Ажиглалт хийх байршил /нийслэл, орон нутагт/	
13	Монгол Улсад ирэх хугацаа, байх хугацаа	
14	Гадаад улсад сонгууль ажигласан туршлага /улсын нэр, он/	

/...../


(гарын үсэг)

(гарын үсгийн тайлал)

Сонгуулийн ерөнхий хорооны  
2021 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн  
29 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт

Ажиглагчийн үнэмлэхийн загвар

..... СОНГУУЛЬ – ..... он



АЖИГЛАГЧ

/нэр/

/төлөөлж буй байгууллага/

Нүүрэн тал

Дугаар .....

Нь..... нам /эвсэл/-аас

Нийслэлийн /..... аймгийн/  
..... дүүрэг /сум/-ийн ..... дугаар хэсгийн санал  
авах байранд ажиглагчаар томилогдон бүртгэгдсэн тул үнэмлэх  
олгов.

..... дугаар хэсгийн хорооны дарга

Тэмдэг /...../

Ажиглагчийн эрх санал хураалтын албан ёсны дүн гарснаар дуусгавар болно.

Ар тал

Сонгуулийн ерөнхий хорооны  
2021 оны 3. дугаар сарын 19.-ны өдрийн  
19. дугаар тогтоолын 6 дугаар хавсралт


Гадаадын ажиглагчийн үнэмлэхийн загвар

..... СОНГУУЛЬ - ..... он



ГАДААДЫН  
АЖИГЛАГЧ

Дугаар .....



..... Улсын иргэн  
..... нь  
.....  
.....-аас  
/төлөөлж буй байгууллагын нэр/

.....20... оны сонгуульд  
ажиглагчаар бүртгэгдсэн тул үнэмлэх олгов.

Монгол Улсын  
Сонгуулийн ерөнхий хорооны дарга  
Тамга

/...../

Ажиглагчийн эрх санал хураалтын албан ёсны дун гарснаар дуусгавар болно.

**Тайлбар:** Энэхүү үнэмлэх нь монгол, англи хэл дээр байх бөгөөд аюулгүй  
ажиллагааны заавар, зөвлөмжийн хамт ажиглагчдад олгогдоно.